



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/359

Мандалговь

“Хайртай” төслийг хамтран хэрэгжүүлэхэд  
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны А/262 тоот захирамж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Хурд” хамтлагийн санаачилгаар, Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор орон даяар хэрэгжиж буй соёл, урлагаар дамжуулан залуу, хойч үедээ эх оронч хүмүүжил төлөвшил, ёс суртахуун, гоо зүйн боловсрол олгох зорилго бүхий “Хайртай” төслийг орон нутагт хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргасугай.

Хоёр. Төсөл хэрэгжүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Төслийн зардалд 11.270.217 (Арван нэгэн сая хоёр зуун далан мянга хоёр зуун арван долоо) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191014